## САНХҮҮ БҮРТГЭЛ, ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТИЙН ТАСГИЙН ОРЛОГО, ШИМТГЭЛИЙН БАЙЦААГЧ Д.ЖАРГАЛМААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ. "Нийгмийн даатгалын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | 1.1.1 Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулах, дээд газраас ирүүлсэн холбогдох журам, дүрэм, заавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах | Иргэд даатгуулагчдыг мэдээллээр хангаж, хууль тогтоомжийг сурталчилсан байна. | 2023 онд нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 4 чиглэл 2 журам батлагдсаныг ажил олгогчид танилцуулсан. Төсөвт болон аж ахуй нэгж байгууллагад албан бичгээр хүргүүлсэн. Хуримтлагдсан авлагатай 12 байгууллагын 200 гаруй албан журмын даатгуулагчдад сургалт хийсэн. | Ажил олгогч, албан журмын даатгуулагч, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчидийн нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилсэн байна. Төсөвт болон аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодогчдын 2 удаагын сургалтыг зохион байгуулах | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, заавар, зөвлөмжүүдтэй тухай бүр танилцан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Нийгмийн даатгалын тайлан хүлээн авах, шимтгэлтэй холбоотой заавар журам 2024 онд 12 ирснийг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлж, хэлтсийн хүлээлгийн танхимд байрлах мэдээллийн самбарт байрлуулсан. Мөн Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар ажил олгогчийн нягтлан бодогчдод албан бичгээр хүргүүлсэн. Мөн хэлтсийн даргын өгсөн үүргийн дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 11 байгууллага болон хувиарт байгууллагын 400 гаруй даатгуулагчидад Нийгмийн даатгалын ач холбогдол анхаарах асуудал сэдэвт сургалтыг хийсэн. Мөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой мэдээллийг ажил олгогчдод тухай бүр өгч хамтран ажилласан. Нэр бүхий 5 сумдын ажил олгогчын нягтлан бодогчдод онлайнаар 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан. | 2024-01-01 2024-12-31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | 1.1.2 Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, сангийн орлогын бааз суурийг өргөжүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж байгууллага, даатгуулагчдыг шинээр хамруулах ажлыг зохион байгуулах | Шинээр хамруулсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо, даатгуулагчдын тоог суурь түвшнээс 9 хувиар нэмэгдүүлсэн байна | 2023 онд 78 ажил олгогчийн 283 даатгуулагчийг албан журмын даатгалд хамруулсан байна. | 18 ажил олгогч, 88 албан журмын даатгуулагчийг шинээр нийгмийн даатгалд хамруулах | Тайлант хугацаанд Хэнтий аймгийн хэмжээнд 89 ажил олгогчийн 286 албан журмын даатгуулагчийг нийгмийн даатгалд хамруулснаас Хэрлэн сумын хэмжээнд шинээр 43 аж ахуй нэгж, байгууллагын 155 албан журмын даатгуулагчийг нийгмийн даатгалд хамруулсан. Одоогийн байдлаар 991 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, шимтгэл төлөлтийн тайлан тооцоог хүлээн авч баталгаажуулан ажиллаж байна. Албан журмын даатгуулагч 12955, 2024 оны байдлаар аймгийн хэмжээнд шинээр 286 албан журмын даатгуулагч хамруулан бүртгэж тайлан тооцоог хүлээн авч цалин санг нэмэгдүүлсэн. Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг сумдын байцаагчдад өгч, татварын хэлтэс улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран ажиллаж үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчийн мэдээллийг тулгаж шинээр нийгмийн даатгалд хамрагдвал зохих аж ахуй нэгж байгууллагын судалгааг гарган хамруулах ажлыг зохион байгуулж байна. Үйл ажиллагаа явуулдаг боловч, нийгмийн даатгалд хамрагдаагүй Хэрлэн сумын12 байгууллагад албан бичгээр мэдэгдэл хүргүүлж нийгмийн даатгалд хамруулсан. | 2024-01-01<br>2024-12-31 | 96 |
| **ХОЁР. “Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө жигд хангаж биелүүлэх, даатгуулагчдын мэдээллийн санг бүрдүүлэх, тайлагнах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |

132

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | 2.1.1 Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангах биелүүлэх | Батлагдсан 19546,5 сая төгрөгийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар, өссөнөөр жигд биелүүлж ажиллана. | 2023 оны байдлаар Хэрлэн сумын хэмжээнд Нийгмийн даатгалын санд 14969513.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл хуримтлуулхаас 15445451.1 сая төгрөгийг хуримтлуулж сангийн орлогын төлөвлөгөөг 103,1 хувиар биелүүллээ. | 2024 оны байдлаар 18647.4 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлж төлөвлөгөөг жигд хангаж биелүүлсэн байна. | 2024 оны байдлаар аймгийн хэмжээнд 89 ажил олгогчийн 286 даатгуулагчийг нийгмийн даатгалд хамруулсан. Үүнээс Хэрлэн сумын хэмжээнд 43 ажил олгогч, албан журмын даатгалд 286 даатгуулагчийг шинээр тус тус нийгмийн даатгалд хамруулж цалин санг 318.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар бүр жигд хангаж биелүүлж байна. 2024 оны байдлаар нийгмийн даатгалын санд 51721.4 сая төгрөг санд төвлөрүүлхээс 54810.5 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлж албан журмын даатгуулагчийн орлогын төлөвлөгөөг 106 хувиар давуулан биелүүллээ. Хэрлэн сумын хэмжээнд 18647.4 сая төгрөг төвлөрүүлхээс 22158.9 сая төгрөг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 118.8 хувиар биелүүлсэн. | 2024-01-01 2024-12-31 | 100 |

133

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 2.1.2 Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах талаар нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, оны эхний үлдэгдлээс бууруулах, үр дүнг тооцож, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг НДЕГ-т хүргүүлэх | Хэрлэн сумын хэмжээнд хуримтлагдсан авлага үүсгэсэн 55 ажил олгогчийн 126.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах | Хэрлэн сумын хэмжээнд оны эхэнд 50 байгууллагын 143,5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байснаас 69.6 хувь буюу 44 байгууллагын 99,9 сая төгрөгийг барагдуулсан байна. 73 аж ахуйн нэгжийн 541,2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагад дансны хаалт тавьж 382,1 сая төгрөгийн татан авч, нийгмийн даатгалын санд [illegible] | Нийгмийн даатгалын сангийн оны эхний авлагыг 30-оос доошгүй хувиар бууруулах /31754.4 сая төгрөг/ | Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлагыг бууруулах чиглэлээр НДЕГазраас ирүүлсэн чиглэл, заавар, зөвлөмжтэй танилцаж үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажилласан. Мөн хуримтлагдсан авлагыг бууруулах чиглэлийг сумдын байцаагчдад албан бичгээр 2024 оны 05-р сард хүргүүлсэн. Нийгмийн даатгалын системийн хэмжээнд шинэ систем нэвтэрч авлага цэс 2024 оны 06 сард нэмэгдсэн. Тус цэсийг ашиглаж төсөвт байгууллагын авлагыг ангилж авлага барагдуулах, хамтран ажиллах албан бичгийн Эрүүл мэндийн газар Боловсролын газар , Соёл урлагын газарт болон Санхүү төрийн сангийн хэлтэст албан бичгээр хүргүүлж хамтран ажилласан. 2024 оны эхний Хэрлэн сумын хэмжээнд 55 байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн авлага нийт 126.9 сая төгрөг байснаас жилийн эцсийн байдлаар 85.6 хувь буюу 108.4 саяийг барагдуулаад байна. Барагдаагүй үлдсэн 18.5 сая төгрөгийн авлагын 11.5 хувь Жижиг-Эрдэнэ ХХК хариуцагч нас барсан ажиллагаа явуулах боломжгүй бөгөөд 7.0 сая төгрөг нь шүүхийн шийдвэртэй гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа авлага болно. 2023 оны жилийн эцсээр нийт 2980,7 сая төгрөгийн авлагатай гарсан. Оны эхний авлагаас 95.0% буюу 2826,9 сая төгрөгийг барагдуулсан байна. Үүнээс үлдэгдэл 153,8 сая төгрөг байгаагаас 112,3 сая төгрөг нь шүүхийн шийдвэртэй гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа авлага, 22,1 сая төгрөгийн авлага нь эзэн холбогдогч нас барсан, татан буугдсан байгууллагын авлага бөгөөд үлдсэн 19.1 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулхаар ажиллаж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар үрсгал авлага 850,1 сая гарахаар урьдчилсан байдлаар тооцож байна. 2024 онд шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн албанд нийт 12 аж ахуй нэгжийн 118.6 сая төгрөгийн найдваргүй авлагыг шилжүүлж, 112,1 сая төгрөгийг барагдуулаад байна. Нийгмийн даатгалын шимтгэлээ хуулийн хугацаанд төлөөгүй 174 аж ахуй нэгж байгууллагын 1158,5 сая төгрөгт дансны хаалт хийж, 1100,1 сая төгрөгийг татан авсан, Хэнтий аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 15 аж ахуй нэгжийн 97,6 сая төгрөгийн авлага барагдуулах нэхэмжлэл гарган нэхэмжлэлийн шаардлагыг хангуулаад байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах ажилд төр олон нийтийн эрх ашиг хөндөгдсөн, зөрчигдсөн гэж үзэн Хэнтий аймгийн Прокурорын газрын төр төлөөлсөн хяналтын прокуротой 2022 оноос хойш байнга хамтран ажиллаж байна. | 2024-01-01<br>2024-12-31 | 100 |

134

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 2.1.3 Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. Ажил олгогч даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | Хэнтий аймгийн хэмжээнд тайлан гаргадаг 912 ажил олгогчийг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 3-НД78 тайланг тоон гарын үсгээр хүлээн авч баталгаажуулсан. | Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлж, ажил олгогч, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг шуурхай авсан байна. | Нийгмийн даатгалын шинэ системд 1000 гаруй ажил олгогчийг хувиарлаж 991 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хүлээн авч хуулийн хугацаанд баталгаажуулсан. Мөн шинэ системийн холболтыг хороо нэг бүрээр тулган шалгаж системд холбогдоогүй 300 гаруй ажил олгогчийг эрхийн тохиргоох хийж мэдээллийн санд оруулсан. Байгууллагын дарга нягтлан бодогч солигдсон мэдээлэл шинэчлэх 52 хүсэлтийг албан бичиг болон цахимаар хүлээн авч шуурхай шийдвэрлэсэн. | 2024-01-01<br>2024-12-31 | 100 |
| 7 | 2.1.4 Нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлттэй холбоотой мэдээ, тайлан судалгаа гаргах, дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээ авах | Тайлан мэдээ хугацаандаа чанартай гарсан байна. | Сар бүрийн 1-ний болон 15 -ний мэдээг тогтмол гаргаж НДЕГазарт хүргүүлсэн. | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын мэдээг гарган дээд шатны удирдлагыг мэдээллээр хангасан байна. | Нийгмийн даатгалын системийн хэмжээнд шинэ систем нэвтэрч байгаатай холбогдуулан ажил олгогчийн 8 удаагийн судалгаа, нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагатай холбоотой 23 удаагийн мэдээг тус тус гаргаж НДЕГазарт хүргүүлсэн. | 2024.01.01<br>2024.06.31 | 100 |

| ДӨРӨВ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| В | 3.1. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх | Албан хаагчийн эзгүй байгаа үед орлон гүйцэтгэж ажилласан байна. | Хүний нөөцийн мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн | Албан хаагчийн эзгүй байгаа үед орлон гүйцэтгэж ажилласан байна. | Хэлтсийн даргын тушаалаар үүрэг болгосны дагуу орлого, шимтгэлийн байцаагчийн албан үүргийг давхар хариуцан ажиллаж хугацаатай мэдээ, тайлан, судалгааг тухай бүр хуулийн хугацаанд гаргаж, ажлын байрны тодорхойлолтонд заагдсан ажил үүргийг гүйцэтгэн ажиллаж байна. Мөн шинэ бүтэц орон тоогоор ажиллаж байгаатай холбогдуулан 2024 оны 09 дүгээр сараас хүний нөөц хуулийн мэргэжилтний ажлыг давхар хариуцаж ажиллаж байна. 2024 онд хүний нөөцийн 12 удаагийн мэдээ 64 удаагийн судалгааг тухай бүр дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Давхардсан тоогоор 123 ажилтаны мэдээллийг хүний нөөцийн 5 программд оруулсан. Мөн төрийн албаны төв зөвлөлийн шалгалт, аймгийн ЗДТГ-н Хяналт шинжилгээ үнэлгээний шалгалтуудад сайн шалгагдсан. Шинээр зэрэг | 2024-01-01<br>2024-12-31 | 100 |
| В | 3.2. Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, НД | -Ёс зүйн гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангаж, хууль дүрэм зөрчигдөөгүй байх | Ёс зүйг гэрээ байгуулж мөрдөн ажилласан. | Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, НД байгууллагын | Төрийн албаны тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн, эрхээ эдэлж, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, нийгмийн даатгалын байгууллагын ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллаж мэргэжлийн ажил үйлчилгээг ажил олгогч, иргэд, даатгуулагчдад түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. | 2024-01-01<br>2024-12-31 | 100 |

136.

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | ...пд байгууллагын ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллах | - Ажлын цаг ашиглалт, сахилга бат мөрдөгдөн ажилласан байна. | Ажлын цаг ашиглалт сайн, гомдол санал ирээгүй болно | Ёс зүйн дүрэмийг мөрдлөг болгон ажиллаж хэвшсэн байна. | 2024 оны хагас жилийн байдлаар албан хаагч миний ёс зүй, ажлын цаг ашиглалттай холбоотой гомдол санал ирээгүй болно. Ар гэрийн гачигдлаар зайлшгүй чөлөө авсан даруй зайнаас цахимаар ажиллаж, нийгмийн даатгалын ажил үйлчилгээг тасалдалгүй хэвийн явуулж, мэдээ тайлангаа хугацаанд гаргасан. | 2024-01-01<br>2024-12-31 | 100 |
| 10 | 3.3. Аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн санал өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх | -Ирсэн өргөдөл, гомдлын тоо | Албан журмын шимтгэл төлөлттэй холбоотой 2 гомдол ирснийг шийдвэрлэсэн | Ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэл, албан бичгийн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна | Аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 22 албан бичиг цохогдож ирсэнтэй тухай бүр танилцаж, хуулийн хүрээнд асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж ажилласан. Мөн хугацаатай албан бичиг 2024 байдлаар 16 ирснийг тухай бүр шийдвэрлэж хариуг өгсөн. Хүний нөөцийн чиглэлээр 3 өргөдөл ирснийг шийдвэрлэсэн. | 2024-01-01<br>2024-12-31 | 100 |
| | | -Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж хэвшсэн. | | | 2024-01-01<br>2024-12-31 | 100 |
| 11 | 3.4. Ажил олгогч, даатгуулагчын мэдээллийн нууцыг бусдад задруулахгүй ажиллах үүрэг хүлээх. | Аливаа мэдээллийн нууцийг бусдад задруулахгүй ажилсан байх. | 2023 онд хувь хүний болон байгууллагын нууцтай холбоотой гомдол санал гараагүй болно. | Ажил олгогч, даатгуулагчын мэдээллийн нууцыг бусдад задруулахгүй ажиллаж өргөдөл, гомдол ирээгүй байна | Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чандлан баримталж Төрийн нууцын тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн ажиллаж ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг бусдад задруулаагүй болно. Албан ажлын зайлшгүй шаардлага, төрийн байгууллагын хүсэлтээр даатгуулагчтай холбоотой 5 удаагийн мэдээлэл, лавлагааг эрх бүхий албан тушаалтны цохсон албан бичгийн дагуу гаргаж өгсөн. | 2024-01-01<br>2024-12-31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | 3.5. Архивын материалыг цаг тухайд нь хүлээлгэн өгөх, албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг дагаж мөрдөж ажиллах | Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо | 2023 онд хэлтсийн архивт төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагын баримт 2022 оны 7 ботийг хүлээлгэн өгсөн. | Архивын материалыг 2024-01 улиралд багтаан хүлээлгэн өгч албан хэрэг хөтлөлт, архивын баримт холбогдох стандарт, зааварт нийцүүлэн ажилласан байна | Ажил олгогчийн нийгмийн даатгалын тайланг тоон гарын үсгээр 2021 оноос хүлээн авч хэвшсэн. Хэнтий аймгийн хэмжээнд 2023 онд 912 ажил олгогч тооны гарын үсгээр 22 байгууллага цаасаар тайлан ирүүлснийг хүлээн авч баталгаажуулсан бөгөөд НДЕГ-ДАМГазраас ирүүлсэн чиглэл, Салбарын архивын ажлын зааврын дагуу стандартын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн 6 боть баримтыг хэлтсийн архивт 2023 оны 01-р улиралд бүрэн хүлээлгэн өгсөн. 2023 оны баримтанд НДЕГазрын төлөвлөгөөт хяналт, шалгалт хийгдэж зөрчилгүй гэж үнэлсэн. | 2024-01-01<br>2024-12-31 | 100 |
| 13 | 3.6. Ашиг сонирхлын зөрчлөөс өөрийгөө урьдчилан сэргийлж ажиллах. | Ашиг сонирхлын зөрчилөөс урьдчилан сэргийлэх сургалтанд хамрагдсан тоо | 2023 онд 2 удаагийн сургалт хамрагдсан | Сургалтанд 1-ээс доошгүй удаа хамрагдсан байна | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж Төрийн албаны тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн ажилласан. Авлига, ашиг сонирхолтой холбоотой сургалтанд аймгийн ЗДТГ болон Авлигатай тэмцэх газраас 2024.05.10-ны өдөр хамрагдсан. Эрх бүхий албан тушаалтны хувьд хөрөнгө орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргасан болно | 2024-01-01<br>2024-12-31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | 3.7. Үнэлгээний төхөөрөмжийг зориулалтын дагуу бүрэн гүйцэд ажиллуулж хэвших | Үйлчлүүлсэн иргэдийн тоо, үнэлгээний чанар | Үнэлгээний төхөөрөмжийг тогтмол ажиллуулж ажил олгогч, иргэд даатгуулагчид үйлчилгээ үзүүлж, үнэлгээ авсан. | Үнэлгээний төхөөрөмжийг зориулалтын дагуу бүрэн гүйцэд ажиллуулж хэвшсэнээр иргэд, даатгуулагч, албан хаагчийн харилцаа хандлага сайжирсан байна | Төрийн байгууллагын үйлчилгээг ажил олгогч, иргэд даатгуулагчдад нэг цэгээс хөнгөн шуурхай, чирэгдэлгүй хүргэх ил тод нээлттэй байх зорилгоор суурилуулсан үнэлгээний төхөөрөмжийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж байна. Үйлчилгээ авсан даатгуулагчаар ажлаа үнэлүүлж байгаа бөгөөд одоогийн байдлаар муу дунд үнэлгээ өгөөгүй болно. | 2024-01-01<br>2024-12-31 | 100 |

## НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хүний нөөцийн ажлыг давхар хариуцан ажиллаж шаардлагатай мэдээ судалгаа тайланг гаргах, өөрчлөлтийг тухай бүр цахим программуудад оруулах ажлыг зохион байгуулах | | Хэлтсийн хүний нөөцийн ажлыг давхар хариуцан ажиллаж, хүний нөөцийн 5 төрлийн программыг ашиглаж, ажиллагсадын мэдээллийг тухай бүр цахим санд оруулсан. Мөн 41 албан хаагчийн хувийн хэргийн материалыг шинэ зааврын дагуу эмхэлж, цэгцэлсэн. | | Хэлтсийн хүний нөөцийн ажлыг давхар хариуцан ажиллаж, хүний нөөцийн 5 төрлийн программыг ашиглаж, ажиллагсадын мэдээллийг тухай бүр цахим санд оруулсан. Мөн 37 албан хаагчийн хувийн хэргийн материалыг шинэ зааврын дагуу эмхэлж, цэгцэлсэн. Сар бүрийн хүний нөөцийн тайланг Green программаас хөрвүүлж НДЕГ-ТГазарт хүргүүлсэн. 2024 оны байдлаар хүний нөөцтэй холбоотой 62 төрлийн судалгааг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн программд ажиллагсадын мэдээллийг дахин тулгаж, үнэн зөв баазыг бүрдүүлсэн. Мөн зэрэг дэв ахиулах 18, шинээр авах 2 байцаагчийн материалыг бэлтгэн хүргүүлж, захирамж гаргуулсан. Шинээр томилогдсон, чөлөөлөгдсөн зэрэг албан хаагчтай холбоотой Б тушаалын төслийг боловсруулж эрх бүхий албан хаагчаар баталгаажуулан ажиллаж байна. Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог тухай бүр нийтэд зарлаж 5 сул орон тоог нөхсөн. Давхардсан тоогоор 18 орон тоог нийтэд ил тод нээлттэй зарласан. Мөн 2024 онд улсын байцаагчийн эрх шинээр авсан 3 байцаагчийн цалингийн шатлалыг ахиулсан. Мэргэшлийн "Зөвлөх", зэрэгтэй 9, "Тэргүүлэх" зэрэгтэй 3 байцаагчийн материалыг тус тус НДЕГ-т хүргүүлэн, ирсэн тушаалын дагуу нэмэгдлийг олгож байна. | 2024-01-01<br>2024-12-31 | 100 |

*Но.*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Асуудлаас шийдэлд уралдаанд оролцох | | | | Хэнтий аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан АСУУДЛААС ШИЙДЭЛД уралдаанд багаараа амжилттай оролцсон. Төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр гаргасан киоск машинтай болох санал 1-рт эрэмбэлэгдсэн. ЗДТГазартай хамтран ажиллаж уралдааны хүрээнд КИОСК машинтай болсон. Ингэснээр ажил олгогч, иргэд даатгуулагчид төрийн үйлчилгээг нэг цэгээс хөнгөн шуурхай авах боломж бүрдсэн. АСУУДЛААС ШИЙДЭЛД уралдааны 2 удаагийн тайлан илтгэлийг нэгтгэж, танилцуулсан. Тус уралдаанд багаараа 3-р байранд шалгарсан. Мөн тус уралдааны хүрээнд газрын архив эмхэлж цэгцлэх ажил хийгдсэнтэй холбоотойгоор архивт ажиллаж хувийн хэргийн 2000 гаруй тэтгэврийн хувийн хэргийн бүртгэлийг хийсэн. | 2024-03-01<br>2024-10-01 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| “ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |

/41/

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | Арга хэмжээ №1.1. Монгол бичгийн чадварт суралцах | Үндэсний бичиг соёлоо мэддэг, уншиж бичих чадвартай болох | Анхан шатны сургалт хамрагдсан | Сургалтанд хамрагдаж мэдлэг дээшилсэн байна. | Үндэсний бичигт суралцаж унших, бичих чадвартай байх шаардлагын дагуу өөрийн мэдлэг ур чадварыг дээшлүүлж, НДЕГазраас хийж дунд хугацааны цахим сургалтанд цахимаар хамрагдаж байна. 2024 оны байдлаар 5 удаагийнн сургалтанд хамрагдсан. Мөн аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан НЭМЭХ ЦЭНЭГ НЭГ ЦАГ сэдэвт 22 удаагийн цахим сургалтанд тухай бүр хамрагдсан. НДЕГ-аас хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар зохион байгуулсан танхимын сургалтанд УБ хотноо хамрагдсан. Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтанд бэлтгэх цахим 12 удаагийн сургалтанд хамрагдсан | 2024-01-01 2024-12-31 | 100 |
| 16 | Арга хэмжээ №1.2. Хууль тогтоомжийн өөрчлөлттэй тухай бүр танилцаж мэдлэг чадвараа дээшлүүлэх, зохион байгуулсан сургалтанд хамрагдах | Сургалтанд хамрагдсан тоо | Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан танхимын 1 онлайн 16 удаагын сургалт тус тус хамрагдсан | 1-ээс доошгүй | | 2024-01-01 2024-12-31 | 100 |
| | | Мэдлэг чадвараа дээшлүүлсэн байдал. | Өөрийн мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн. | Хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн байна | Өөрийн мэдлэг ур чадварыг дээшлүүлхийн тулд салбарын болон бусад хууль тогтоомжийг тус тус судалж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн өөрийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтанд хамрагдаж байна. | 2024-01-01 2024-12-31 | 100 |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: Д.ЖАРГАЛМАА